



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН
ТАЙЛАН Ч.ЗОРИГТБААТАР

2025 оны 1 сарын 15
Улаанбаатар хот


Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Ч.Зоригтбаатар миний бие 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль, Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон Банкны Дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 4 удаа хуралдсан бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн **2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №Т/24-16** дугаартай хурлаар “Банкны тухай хуулийн хязгаарлалтыг хангах төлөвлөгөө 2024-2026 он”-г хэлэлцэн тус төлөвлөгөөг банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн; банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 11.00 цагт банкны төв байрны 15 давхарт “банкны тухай хуулийн хязгаарлалтыг хангах төлөвлөгөө 2024-2026 он” болон төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцүүлэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлахаар шийдвэрлэсэн; банкны эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах; дотоод аудитын газрын бусад нэгжийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг үнэлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцсэн бөгөөд дээрх асуудлуудыг хэлэлцэхэд саналын зөрүүтэй байр суурь байгаагүй болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтэй баталсан.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн **2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн №Т/24-17** дугаартай хурлаар Тээвэр хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 14 цаг 00 минутад банкны төв байр буюу Шангри-ла оффисын 15 давхарын хурлын танхимд “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Баттүшигийг Монголбанкны



зөвшөөрлийн албан бичгийг үндэслэн томилох тухай” асуудлыг хэлэлцүүлэхээр хурлыг товлосон. Миний зүгээс хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй болно.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн **2024 оны 12 дугаар сарын 16-ны** өдрийн №Т/24-18 дугаартай хурлаар дотоод аудитын газрын ерөнхий аудитын хэлтсийн аудитор албан тушаалд үндсэн ажилтнаар аудиторуудыг томилохоор шийдвэрлэсэн.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн **2024 оны 12 дугаар сарын 30-ны** өдрийн №Т/24-19 дугаартай хурлаар комплаенсийн газрын 2024 оны 04 дүгээр улирлын тайланг хэлэлцэж, тус тайланг холбогдох журмын дагуу Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хуралд оролцсон байдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан бөгөөд тус хурлаар нийт 6 асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гарган Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч ажилласан бөгөөд тус хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

1. Банкны их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/
2. Банкны Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороодын үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын тайлан
3. Банкны Премиум салбарт хийсэн аудитын шалгалтын тайлан
4. Банкны Зүүн дөрвөн зам салбарт хийсэн аудитын шалгалтын тайлан
5. Банкны сүлжээний хамгаалалт, аюулгүй байдлын үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын тайлан
6. Дотоод аудитын газраас бусад нэгжийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг үнэлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал

Дээрх асуудлуудыг хэлэлцэж дараахь санал дүгнэлтийг гарган гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож ажилласан. Үүнд:

1. Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороодын хурлаас гарч буй шийдвэрүүд хүчин төгөлдөр байх үүднээс хороодын бүрэлдэхүүнийг тэгш биш сондгой болгох; хороодын хурлуудын зохион байгуулалтыг чанартай болгох, хороо тус бүрийг тогтсон хуваарийн дагуу хуралдуулах, хороодын хурлын ирц болон хурлаас гарч буй шийдвэр гаргалтад тус хорооны дарга хяналт тавьж ажиллах талаар;



2. Салбарын захирал томилогдоогүй үед тухайн салбарын захирлын албан тушаалыг хавсран гүйцэтгэж буй ахлах эсхүл ажилтан нь хавсран гүйцэтгэж буй талаар Гүйцэтгэх захирлын тушаал гарсан эсэхэд салбарын удирдлага хариуцсан чиг үүргийн нэгж хяналт тавьдаг байх;

3. Компанийн засаглалын кодекс болон Зохистой засаглалыг бүрдүүлэх үүднээс Гүйцэтгэх захирлын дэргэдэх Хяналт шалгалтын газар эсхүл хэлтсийг байгуулах шаардлагатай гэж үзсэн тул энэ талаар судлах;

4. Салбарын ажилтнуудад зориулсан сургалт, дадлагын ажлыг илүү чанартай, үр дүнтэй байлгах үүднээс дотоод нөөц бололцоог ашиглан сургалтыг шаталсан видео хэлбэрээр зохион байгуулах ажлыг судалж, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах;


5. Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаа дунд байна гэж дүгнэгдсэн тул цаашид банкны мэдээллийн аюулгүй байдлын ажлыг илүү сайжруулахад анхаарах, 2024 оны хөндлөнгийн аудитын нэвтрэлтийн тестийн (penetration test) ажлыг хийж гүйцэтгэхэд анхаарах; халдлага илрүүлэх системээр ирж буй халдлагын тайланд анхаарал хандуулах, түүний дагуу зохих арга хэмжээг цаг тухай бүрт авч ажиллах. Энэ талаар холбогдох газар, нэгжийн ажлын байрны тодорхойлолтод тусгах;

6. Дотоод аудитын газраас бусад нэгжийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг үнэлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналтай танилцаж, тус журмын нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг батлуулах саналтайгаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хуралдсан бөгөөд тус хурлаар Дотоод аудитын газрын ерөнхий аудитын хэлтсийн туршилтын 3 сарын хугацаатай томилогдсон ажилтнуудын туршилтын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлантай танилцаж, тус аудитуудыг үндсэн ажилтнаар томилох тухай саналыг хорооны гишүүд дэмжиж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн
удирдлагын хорооны хуралд оролцсон байдал**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо нь 2024 оны 10 дугаар сарын 28-нд хуралдсан бөгөөд тус хурлаар нийт 4 асуудал хэлэлцсэн. Үүнд:



1. Тусгай активын нэгжийн гүйцэтгэлийн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/
2. Эрсдэлийн нэгдсэн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/
3. Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт өөрчлөлт оруулах санал
4. Комплаенсийн газрын гүйцэтгэлийн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/

Дээрх асуудлуудыг хэлэлцэж, Гүйцэтгэх удирдлагад дараах санал дүгнэлтийг өгч ажилласан. Үүнд:

1. Тусгай активын нэгжийн гүйцэтгэлийн 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх тайлантай танилцсан бөгөөд 2025 оны 1 дүгээр улиралд багтаан 2024 оны жилийн тайланг танилцуулахыг үүрэг болгов.

2. Эрсдэлийн 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх нэгдсэн тайлан болон эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулан тухай саналтай танилцаж, эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд дараах байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргав. Үүнд:

- банк нь нэг арилжааны банканд барьцаагүй байршуулах харилцах, хадгаламжийн нийт дүнг дотоодын арилжааны банкны хувьд [] хэтрүүлэхгүй, ВВВ буюу түүнээс дээш үнэлгээтэй гадаадын банкны хувьд [] хэтрүүлэхгүй байхаар тус саналыг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдвэрлэв.

3. Банкны комплаенсийн газрын 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх тайлантай танилцаж, сэжигтэй гүйлгээний тайлан, мэдээллийг сайжруулах мөн сэжигтэй гүйлгээний тохиолдол гарах үед мэдээлэл (alert) ирдэг болох үүднээс программын түвшинд мэдээллийн технологийн газартай хамтран хийх талаар зөвлөв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо нь **2024 оны 11 дүгээр сарын 27-нд** хуралдсан бөгөөд тус хурлаар Банкны чанаргүй активын дотоод үнэлгээний тухай хэлэлцсэн бөгөөд банкны 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх чанаргүй активын дотоод үнэлгээтэй танилцаж, тус тайланг зохих журмын дагуу Монголбанканд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон.



**Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их
хэмжээний хэлцлийн тайлан**

Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болохыг тэмдэглэж байна.

Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын багийн хооронд мэдээлэх процесс, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу хэвийн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар





ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН
ТАЙЛАН Б.ОЮУНЦАЦРАЛ

2025 оны 1 сарын 15
Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль, Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон Банкны Дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 4 удаа хуралдсан бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн **2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн №Т/24-16** дугаартай хурлаар “Банкны тухай хуулийн хязгаарлалтыг хангах төлөвлөгөө 2024-2026 он”-г хэлэлцэн тус төлөвлөгөөг банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн; банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 11.00 цагт банкны төв байрны 15 давхарт “Банкны тухай хуулийн хязгаарлалтыг хангах төлөвлөгөө 2024-2026 он” болон төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцүүлэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлахаар шийдвэрлэсэн; банкны эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах; дотоод аудитын газрын бусад нэгжийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг үнэлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцсэн бөгөөд дээрх асуудлуудыг хэлэлцэхэд саналын зөрүүтэй байр суурь байгаагүй болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтэй баталсан.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн **2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн №Т/24-17** дугаартай хурлаар Тээвэр хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 14 цаг 00 минутад банкны төв байр буюу Шангри-ла оффисын 15 давхарын хурлын танхимд “Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Баттүшигийг Монголбанкны

зөвшөөрлийн албан бичгийг үндэслэн томилох тухай” асуудлыг хэлэлцүүлэхээр хурлыг товлосон. Миний зүгээс хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд зорүүтэй байр суурь байгаагүй болно.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн №Т/24-18 дугаартай хурлаар дотоод аудитын газрын ерөнхий аудитын хэлтсийн аудитор албан тушаалд үндсэн ажилтнаар аудиторуудыг томилохоор шийдвэрлэсэн.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №Т/24-19 дугаартай хурлаар комплаенсийн газрын 2024 оны 04 дүгээр улирлын тайланг хэлэлцэж, тус тайланг холбогдох журмын дагуу Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх

Аудитын хорооны хуралд оролцсон байдал

Миний бие Аудитын хорооны хурлыг тус хорооны даргын хувьд удирдан явуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хуралдсан бөгөөд тус хурлаар нийт 6 асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гарган Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч ажилласан бөгөөд тус хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

1. Банкны их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/
2. Банкны Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороодын үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын тайлан
3. Банкны Премиум салбарт хийсэн аудитын шалгалтын тайлан
4. Банкны Зүүн дөрвөн зам салбарт хийсэн аудитын шалгалтын тайлан
5. Банкны сүлжээний хамгаалалт, аюулгүй байдлын үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын тайлан
6. Дотоод аудитын газраас бусад нэгжийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг үнэлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал

Дээрх асуудлуудыг хэлэлцэж дараахь санал дүгнэлтийг гарган гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож ажилласан. Үүнд:

1. Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороодын хурлаас гарч буй шийдвэрүүд хүчин төгөлдөр байх үүднээс хороодын бүрэлдэхүүнийг тэгш биш сондгой болгох; хороодын хурлуудын зохион байгуулалтыг чанартай болгох, хороо тус бүрийг тогтсон хуваарийн дагуу хуралдуулах, хороодын хурлын ирц болон хурлаас гарч буй шийдвэр гаргалтад тус хорооны дарга хяналт тавьж ажиллах талаар;

2. Салбарын захирал томилогдоогүй үед тухайн салбарын захирлын албан тушаалыг хавсран гүйцэтгэж буй ахлах эсхүл ажилтан нь хавсран гүйцэтгэж буй талаар Гүйцэтгэх захирлын тушаал гарсан эсэхэд салбарын удирдлага хариуцсан чиг үүргийн нэгж хяналт тавьдаг байх;

3. Компанийн засаглалын кодексе болон Зохистой засаглалыг бүрдүүлэх үүднээс Гүйцэтгэх захирлын дэргэдэх Хяналт шалгалтын газар эсхүл хэлтсийг байгуулах шаардлагатай гэж үзсэн тул энэ талаар судлах;

4. Салбарын ажилтнуудаа зориулсан сургалт, даллагын ажлыг илүү чанартай, үр дүнтэй байлгах үүднээс дотоод нөөц бололцоог ашиглан сургалтыг шаталсан видео хэлбэрээр зохион байгуулах ажлыг судалж, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах;

5. Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн үйл ажиллагаа дунд байна гэж дүгнэгдсэн тул цаашид банкны мэдээллийн аюулгүй байдлын ажлыг илүү сайжруулахад анхаарах, 2024 оны хөндлөнгийн аудитын нэвтрэлтийн тестийн (penetration test) ажлыг хийж гүйцэтгэхэд анхаарах; халдлага илрүүлэх системээр ирж буй халдлагын тайланд анхаарал хандуулах, түүний дагуу зохих арга хэмжээг цаг тухай бүрт авч ажиллах. Энэ талаар холбогдох газар, нэгжийн ажлын байрны тодорхойлолтод тусгах;

6. Дотоод аудитын газраас бусад нэгжийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг үнэлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналтай танилцаж, тус журмын нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг батлуулах саналтайгаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хуралдсан бөгөөд тус хурлаар Дотоод аудитын газрын ерөнхий аудитын хэлтсийн туршилтын 3 сарын хугацаатай томилогдсон ажилтнуудын туршилтын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлантай танилцаж, тус аудиторуудыг үндсэн ажилтнаар томилох тухай саналыг хорооны гишүүд дэмжиж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд оролцсон байдал

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо нь 2024 оны 10 дугаар сарын 28-нд хуралдсан бөгөөд тус хурлаар нийт 4 асуудал хэлэлцсэн. Үүнд:

1. Тусгай активын нэгжийн гүйцэтгэлийн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/
2. Эрсдэлийн нэгдсэн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/
3. Эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт өөрчлөлт оруулах санал
4. Комплаенсийн газрын гүйцэтгэлийн тайлан /2024 оны 3 дугаар улирлын байдлаарх/

Дээрх асуудлуудыг хэлэлцэж, Гүйцэтгэх удирдалагад дараах санал дүгнэлтийг өгч ажилласан. Үүнд:

1. Тусгай активын нэгжийн гүйцэтгэлийн 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх тайлантай танилцсан бөгөөд 2025 оны 1 дүгээр улиралд багтаан 2024 оны жилийн тайланг танилцуулахыг үүрэг болгов.

2. Эрсдэлийн 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх нэгдсэн тайлан болон эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулан тухай саналтай танилцаж, эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд дараах байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргав. Үүнд:

- банк нь нэг арилжааны банканд барьцаагүй байршуулах харилцах, хадгаламжийн нийт дүнг дотоодын арилжааны банкны хувьд [] хэтрүүлэхгүй, ВВВ буюу түүнээс дээш үнэлгээтэй гадаадын банкны хувьд [] хэтрүүлэхгүй байхаар тус саналыг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдвэрлэв.

3. Банкны комплаенсийн газрын 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх тайлантай танилцаж, сэжигтэй гүйлгээний тайлан, мэдээллийг сайжруулах мөн сэжигтэй гүйлгээний тохиолдол гарах үед мэдээлэл (alert) ирдэг болох үүднээс программын түвшинд мэдээллийн технологийн газартай хамтран хийх талаар зөвлөв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо нь 2024 оны 11 дүгээр сарын 27-нд хуралдсан бөгөөд тус хурлаар Банкны чанаргүй активын дотоод үнэлгээний тухай хэлэлцсэн бөгөөд банкны 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх чанаргүй активын дотоод үнэлгээтэй танилцаж, тус тайланг зохих журмын дагуу Монголбанканд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосон.

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их
хэмжээний хэлцлийн тайлан**

Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болохыг тэмдэглэж байна.

Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын багийн хооронд мэдээлэх процесс, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу хэвийн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн Б.Оюунцацрал

